



2-6 ХҮРТЭЛХ НАСТАЙ ХҮҮХДИЙН НАСНЫ ОНЦЛОГ

Эмхтгэсэн багш Г.Алтантуяа

2017 он
Чойбалсан хот





2 нас

“Бие даасан хүн болж эхлэх нас”

Бие бялдрын хөгжил

- Бугуйн яс бэхжиж эхэлнэ.
- Хоолоо халбагадаж иднэ
- Өмд гутлаа өмсөнө, тайлна
- Саванд эд юмсыг хийнэ, том нүхтэй шүр хэлхэнэ.
- Хөдөлгөөний хурд тэнцвэрээ хадгална
- Бөмбөг өнхрүүлнэ
- Гүйнэ, юманд авирна
- Эрэгтэй хүүхдийн жин 10-12кг, өндөр нь 74,2-83,5см болно.
- Эмэгтэй хүүхдийн жин 9,8-11,8кг, өндөр нь 73,5-82,4 см болно.
- Дээрээ 10, доороо 10 шүдтэй болж сүүн шүд гарч дуусна



2 настангуудын Оюуны хөгжил

- Олон үг ойлгож таны зааврыг дагана.
- Цаас харандаа барьж, зураг зурах аядана.
- Зурагтай ном үзэж, зургийг танина.
- Гараараа юмыг овоолж, салгаж байрлуулна.
- Шоог овоолон түүгээр байшин барилга барина.
- Энгийн үг хэллэг хэлж эхэлнэ.
- Үгийн нөөц нь 250-300 орчимд хүрнэ.
- Дууны өндөр нам, нарийн авиаг ялгаж эхэлнэ.
- Дууны аянд тохируулан хялбар хөдөлгөөн хийнэ.



2 настангуудын Нийгэмшихүйн хөгжил

- Өөрийн хүсэл хэрэгцээ, бодол санаагаа үгээр болон үйлдлээр илэрхийлнэ.
- Хүрээлэн байгаа орчноо чөлөөтэй судална. Ээнэгшин дасгах / цэцэрлэгт нь/
- Таны үйл хөдлөлийг дуурайна.
- Хүмүүсийг сонсоно, үйл хөдлөлийг дагана.
- Ойр дотны хүмүүсийг танина, нэрийг мэдэж дуудна.
- Өөрөө бие дааж хийх, авахыг оролдоно. Хүүхдийн бие даах хүсэл эрмэлзлийг “чи чадахгүй , боль, битгий” гэж хориг тавьснаар тэд зөрүүдлэх, дуугаа хураах, тоомжиргүй хандахад хүргэдэг.
- Энэ насны хэлэх дуртай үг бол “үгүй”, юм л бол үгүй гэдэг. 2 наснаасаа эхлэн зөрүүдэлж эхэлнэ.



3 нас

“Хүний хөгжлийн хамгийн баяр баясгалантай нас”



Бие бялдрын хөгжил

- Нурууны муруйлтууд тогтворжиж эхэлнэ.
- Бие даан нүүр гараа угаана, хувцсаа өмсөнө тайлна.
- Гар хуруу, харааны баримжаа хөгжинө.
- Нэг метр өндөр шат, хананд авирна.
- Үсрэхийг оролдоно. Олс болон зураасан дээр гишгэнэ.
- Бөмбөгийг шиднэ.
- Хөгжмийн аянд хурдан удаан алхана.
- Эрэгтэй хүүхдийн жин 12,2-14,3кг, өндөр нь 83,5-92,4 болно.
- Эмэгтэй хүүхдийн жин 11,8-14,4 кг, өндөр нь 82,4-92,1см болно.



3 настангуудын Оюуны хөгжил



- “Би өөрөө”, “Би хийе”, “Би чадна” гэсэн үгийг хэлэх дуртай байна.
- Хүлээн авах чадвар хөгжинө
- Шинэ үг бүрийг сэтгэл хөдлөн хүлээн авна.
- Зураг зурах тун дуртай болно.
- Юмны өнгө мэдрэх, ялгах чадвар аажмаар сайжирна.
- Улаан, хөх, цагаан, шар өнгийг мэдэрнэ.
- 1200-1500 үгийн дотор ярина.
- Өөрсдийн тоглоом ба юмсын хэлбэрийг мэднэ.
- Олон ба нэг юмыг ялгана.
- Стандарт бус хэмжүүр урт-богино, өндөр-нам гэх хэмжээсийг ялгана, хэлнэ
- Өөрийн бие эрхтэний байрлалыг хэлнэ.



3 настангуудын Нийгэмшихүйн хөгжил



- Магтаалын үг дуулахын тулд бүгдийг хийнэ.
- Ямар нэг үйл ажиллагаанд оролцохдоо “би, би” гэж өөрийгөө харуулахыг эрмэлзэнэ.
- Үгэнд тун амархан орно.
- Эцэг эхдээ хязгааргүй хайртай, өөртөө ч сэтгэл хангалуун байна.
- Энгийн хөдөлмөрийг таны тусламжтайгаар хийнэ.
- Тоглоомноосоо сэтгэлийн асар их баяр баясгалан олж авна.
- Бусадтай хамтран тоглож эхэлнэ.
- Тоглохдоо охид ээж, хөвгүүд аав болж тоглоно.
- Бодит байдал, тоглоом хоёрыг ялгаж чадахгүй түүнээсээ айх үе гарна.



4 нас

“Уяанаас алдуурсан нас”

Бие бялдрын хөгжил



- Хүүхэд өөртөө үйлчилж эхэлнэ, хувцсаа бие даан өмсөж тайлна.
- Үсээ самнах, усанд орох, оймс, хамрын алчуурыг угаахыг оролдоно.
- Ам хамрын алчуур хэрэглэнэ.
- Орон зайд хурдаа тохируулан гүйнэ, өлмий дээрээ үсэрнэ.
- Үсрээд газар бууна, байг онож шиднэ.
- Гурван дугуйтаар дугуй унаж тоглоно.
- Эрэгтэй хүүхдийн өндөр 92-99см, жин нь 14,3-16кг болно.
- Эмэгтэй хүүхдийн жин 14-15,5кг, өндөр нь 92-98 см болно.



4 настангуудын Оюуны хөгжил



- 10-н дотор цээжээр тоолно.
- Харандаа бийр зөв барьж хэрэглэж сурна.
- Эд юмсыг оноож тоолно, дүн тоог хэлнэ.
- “Хэд байна вэ?” гэсэн асуултанд хариулна.
- Гео метрийн хавтгай ба эзэлхүүнт дүрсийг зөв нэрлэнэ, ялгана.
- Машин техникийн нэрийг амархан тогтооно.
- Байрлал, цаг хугацааг илэхийлсэн үгийг яриандаа хэрэглэнэ.
- 4-5 үгтэй өгүүлбэрээр ярина.
- Зурлага зурах гэж эрмэлзэнэ. Том болон жижиг үсгийг ялгана.
- Богино хэмжээний шүлэг уншина.
- Асуулт асууж, асуултанд хариулна.
- Энэ насны хүүхдээр бичлэг, зурлага хийлгэхдээ 5-10 минутаас илүүгүй хугацаанд хийлгэх ба өөрөө сонирхолтой байвал үргэлжлүүлж болно.



4 настангуудын Нийгэмшихүйн хөгжил



- Сониуч, өөртөө итгэлтэй болж дүрэм зааврыг ойлгож тоглоно.
- Харилцааны гол хэлбэр нь өөрийгөө магтана, бие биедээ гайхуулан ярина.
- Өөрсдийн санасан зоргоор аашилна.
- Таагүй байгаа үедээ зөрүүдлэх, бухимдах, муухай ааш гаргах нь багасна.
- Олон зүйлийг бие даан хийх эрмэлзэлтэй өөртөө итгэлтэй болно.
- Бусдын тоглоомоор тоглож байгаад аваад явчихна.
- Энэ наснаас найзтай болж эхэлнэ. Найз нараасаа сонссон этгээд үг яриаг дуурайна.



5 нас

“Тайван тааламжтай нас”

Бие бялдрын хөгжил



- Хөдөлгөөнд нь үсрэлт онцгой байр эзэлнэ.
- Гүйхдээ зүг чигээ өөрчилнө.
- Хоёр дугуй болон хөлөө удирддаг дугуй унана.
- Харааны баримжаагаар хол ойрыг тодорхойлно.
- Зөв бие засаж, ариун цэврийн цаас хэрэглэнэ.
- Хувцсаа цэвэр өмсөх чадвартай болсон байна.
- Эрэгтэй хүүхдийн биеийн өндөр нь 99-105см, жин 16-17,6 кг болно.
- Эмэгтэй хүүхдийн жин нь 15-17кг, өндөр нь 98-105 см байна.



5 настангуудын Оюуны хөгжил



- 10-ын дотор шууд ба урвуу тоолно.
- Өрж байгуулах тоглоомоор янз бүрийн дүрс бүтээнэ.
- Хавтгай болон биет дүрсийг ялган танина. Олон өнцөгт дүрсийг ялгана, танина.
- Юмсыг тэнцүү хувааж хэсгээг бүхэл үүсгэнэ.
- Хөгжмийн хэмнэлд тааруулан хөдөлгөөн хийнэ.
- Эх хэлнийхээ бүх авиаг зөв хэлнэ.
- Энгийн зурлагыг бичнэ. Өөрийн нэрийг бичихийг эрмэлзэнэ.
- Зурагтаа хээ, чимэг оруулна
- Гудамж талбай ба олон нийтий газраар тэмдэг тэмдэглэгээг уншина.



5 настангуудын Нийгэмшихүйн хөгжил



- “Аав”, “ээж” болж дүрд тоглож эхэлнэ.
- Харилцааны баялаг туршлагыг хамт олны дунд байхдаа олж авна.
- Бусад хүүхэдтэй зохицон тоглох, харилцах, асуудлыг шийдвэрлэх гэж оролдоно.
- Шинэ хувцас авч өгөхөд баярлана.
- Нөхөрсөг хоорондоо эвтэй найртай болж ирнэ.
- Хүмүүст магтуулахыг ямагт хүснэ.
- Бусдад санаа бодолоо чөлөөтэй илэрхийлж ойлгуулна.
- Хүний сайн чанарыг өөртөө шингээн авч өөрийн болгоно.
- Аливаад тун ажил хэрэгч байдлаар хандаж эхэлнэ.
- Найзыгаа хүндэтгэж нэрээр нь дуудна. Найзынхаа тухай мэднэ. Миний найз гэж сэтгэлээсээ хандаж, гэр бүлийнхэндээ бахархан ярина.



Хүүхэд хүмүүжүүлэх нь асар том **УРЛАГ.**
Ямар ч хүүхэд төрөлхийн **“МУУ”**
байдаггүй багш, эцэг эх, асран хамгаалагч
бидний хүмүүжүүлэх хэлбэр л
“МУУ ХҮҮХЭД” болгоно.